



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/687

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 74, 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Ховд Брэнд бүтээгдэхүүн шалгаруулах” батлагдсан журамд тусгагдсан үйл ажиллагааны хүрээнд аймгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор бүтээгдэхүүнийг нэгдсэн нэг сав баглаа боодолтой брэнд багц болгох, үйл ажиллагааны зардалд зориулан 20 сая төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааны зардалд зориулан 20 сая төгрөг /хорин сая/-ийг 2021 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтын 4.23-д тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 19-ний өдрийн
А/687 дугаар захирамжийн хавсралт



САВ БАГЛАА, БООДЛЫН ТООЦООЛОЛ

№	Нэр төрөл	Сав баглааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Захиалгын тоо	Нэгж үнэ /төгрөг/	Нийт дүн
1	Монгол архи	Шилэн дугуй сав	грамм	250	1900	800	1 520 000
		Шошго			1900	100	190 000
2	Ааруул	Хайрцаг цонхтой	грамм	300	1900	1 000	1 900 000
3	Шар тос	Шилэн	грамм	300	1900	1 300	2 470 000
		Шошго			1900	100	190 000
4	Хөх тарианы гурил	Цаасан уут	грамм	400	1900	800	1 520 000
5	Сутай цай	Хайрцаг цонхтой	грамм	400	1900	700	1 330 000
6	Нуурын давс	Хайрцаг цонхтой	грамм	300	1900	700	1 330 000
7	Найруулсан чацаргана	Хуванцар сав дугуй	литр	0.33	1900	800	1 520 000
		Шошго			1900	100	190 000
8	Бэлгийн багцын хайрцаг	Бариултай хайрцаг			1900	3000	5 700 000
9	Замын зардал				1	1 140 000	1 140 000
10	Эх бэлтгэл график дизайн				1	1 000 000	1 000 000
Нийт							20 000 000